

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРААС 2020 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДРИЙН 02-02/1596 АЛБАН ТООТООР ИРСЭН КОРОНАВИРУС /COVID-19/ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАЛААР ГАРГАСАН 02-01/1573 ДУГААРТАЙ МЭДЭГДЛИЙН ДАГУУ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН			
1			
2		2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр	
3	Д/д	Хийж гүйцэтгэх ажил	Биелэлт
4	2.1	Эрүүл ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтад заасны дагуу нийтийн тээврийн үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн тээврийн хэрэгсэлд өдөр тутам 2 удаа чийгтэй цэвэрлэгээ хийж, халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлэх	Нийтийн Тээврийн Үйлчилгээний Газартай байгуулсан гэрээний үүргийн дагуу үндсэн нийт 23 чиглэлд ажлын өдөр 180 гаралт, амралтын өдөр 148 гаралт гаргаж өдөр бүр 1 автобус, 6-8 шалгагч хуваарлан эцсийн буудлууд дээр тээврийн хэрэгслийн дотор чийгтэй цэвэрлэгээ хийлгэж байна.
5	2.2	"Нийтийн тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5012:2011 стандартад заасны дагуу нийтийн тээврийн хэрэгслийн дотор, гадна талыг цэвэрлэгээний бодис, материал ашиглан сайтар угааж, цэвэрлэн арчсаны дараа бүх гадаргуу, зорчигчийн бариул зэргийг хавсралтад дурьдсан халдваргүйжүүлэх бодисын уусмалаар шүрших буюу уусмалыг алчуурт шингээж арчих.	Тайлант хугацаанд тус нэгтгэл нь өглөөний гаралт, оройн буултаар нийт 287 тээврийн хэрэгслийн гадна, дотор заал, зорчигчдын бариул, цонх, гадаргууг угааж, ариутгал халдваргүйжүүлэлтийг 121 шалгагч нарыг хуваарлан ажиллуулж байна. 02, 03, 04 дүгээр саруудад ариутгал, халваргүйжүүлэлтийн бодис 6.851 кг жавелин, 19.110 кг угаалгын нунтаг, 24.810 литр спиртыг тараан өгч, баазуудын эмч Б.Цэрэнпил, Алимаа нар хяналт тавин ажиллаж байна.
6	2.3	Зорчигчийн суудлын бүрээсийг 3 хоног тутамд сольж, угаах	1, 2 дугаар баазуудын угаалгын цехийг угаалгын нунтагаар бүрэн хангаж, угаалгын операторууд болон шалгагч нарыг зохион байгуулж, нэгдсэн журмаар 3 хоног тутамд нийт 287 тээврийн хэрэгслийн суудлын бүрээсийг бүрэн угаалгаж, бариул болон цонхны цэвэрлэгээ, ариутгал, халваргүйжүүлэлт хийж ажилласан байна.
7	2.4	Нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ хийхдээ тээврийн хэрэгслийн салхины шил, салхивчийг онгойлгон бүхээгт агаарын урсгалыг солилцуулах	Нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ хийх явцдаа тээврийн хэрэгслийн салхины шил, салхивчийг онгойлгон бүхээгт агаарын урсгалыг солилцуулж хэвшсэн.
8	2.5	Автобусны эцсийн зогсоол бүхэнд зогсохдоо хог хаягдлыг суллан, зайлуулж, зорчигчийн бариулыг халдваргүйжүүлэх бодисын уусмалаар шүрших буюу уусмалыг алчуурт шингээж арчих	Шугам замд 1 автобус, 6-8 шалгагчийн хамт хуваарлан нийт 23 чиглэлийн автобусны эцсийн зогсоолд ажлын өдөр 180 тээврийн хэрэгсэл, амралтын өдөр 148 тээврийн хэрэгслийн дотор заалны бариул, цонх тавцанг тусгай найруулсан ариутгалын бодисоор арчиж, хогийг цэвэрлэж зөөвөрлөн ажиллаж байна.
8	2.5	Автобусны эцсийн зогсоол бүхэнд зогсохдоо хог хаягдлыг суллан, зайлуулж, зорчигчийн бариулыг халдваргүйжүүлэх бодисын уусмалаар шүрших буюу уусмалыг алчуурт шингээж арчих	Шугам замд 1 автобус, 6-8 шалгагчийн хамт хуваарлан нийт 23 чиглэлийн автобусны эцсийн зогсоолд ажлын өдөр 180 тээврийн хэрэгсэл, амралтын өдөр 148 тээврийн хэрэгслийн дотор заалны бариул, цонх тавцанг тусгай найруулсан ариутгалын бодисоор арчиж, хогийг цэвэрлэж зөөвөрлөн ажиллаж байна.
9	2.6	Зорчигчийн бүрээг дотор үйлчлүүлэгчдэд зориулсан спиртэн суурьтай шар халдваргүйжүүлэх бодисыг байршуулсан байх	Тус нэгтгэлийн нийт 287 тээврийн хэрэгслийн зорчигчийн бүхээг дотор үйлчлүүлэгчдэд зориулсан спиртэн суурьтай шар халдваргүйжүүлэх бодисыг 287 ширхэгийг байршуулсан бөгөөд өглөө, оройн буултаар цэвэрлэгээ ариутгал хийхдээ дундарсан гар ариутгагчийг дүүргэн ажиллаж байна.
10	2.7	Тээврийн хэрэгслийн жолооч амны хаалт зүүж, машины хүрд, жолоочийн гар хүрдэг хэсгүүд болон гарыг тогтмол халдваргүйжүүлж хувийн ариун цэврийг сайтар сахиж халдвараас сэргийлэх	Тээврийн хэрэгслийн жолооч амны хаалт зүүж хэвшсэн бөгөөд машины хүрд, жолоочийн гар хүрдэг хэсгүүд болон гарыг тогтмол халдваргүйжүүлтийг 2 цаг тутамд хийж байна.
11	2.8	Ажилчдыг хамгаалах хувцас хэрэгслээр хүртээмжтэй хангах	Нэгтгэлийн хэмжээнд 7 хоногт 2 удаа амны хаалтны хангалт хийж, нийт 1094 ажилтан албан хаагч амны хаалт зүүж хэвшсэн. Мөн дотоод нөөц бололцоогоо ашиглан даавуун амны хаалт хийж, амны хаалтны нөөц бүрдүүлэн ажиллаж байна.
12	2.9	Үйлчлүүлэгчдийг амны хаалт зүүж үйлчлүүлэхийг шаардах	Зорчигч үйлчлүүлэгчдэд хандсан амны хаалт зүүж үйлчлүүлэх тухай наалт санамжийг 287 тээврийн хэрэгсэлд байршуулсан. Мөн 17 автобусны буудал дээр нийт 34 хяналтын ажилтан амны хаалт зүүх тухай нийтэд хандсан зөвлөмж, шаардлагыг тавин ажиллаж байна.
13	2.10	Автотээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2, 10.2.2', 10.2.3, 10.2.3' дахь заалтад зааснаар зорчигчийг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тав тухтай, аюул, осолгүй тээвэрлэх, автотээврийн хэрэгслийн хэрэглээний стандартын үзүүлэлт, шаардлагын хангаж ажиллах	Нийтийн Тээврийн Үйлчилгээний Газартай байгуулсан гэрээний үүргийн дагуу тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тав тухтай, аюул, осолгүй, автотээврийн хэрэгслийн хэрэглээний стандартын үзүүлэлт, шаардлагын хангасан 287 тээврийн хэрэгсэл, нийт 507 мэргэшсэн жолоочоор нийслэлийн иргэд хөдөлмөрчдөд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартыг чанд мөрдөн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.